БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Бугат сумын Эрүүл мэндийн төсвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/43/НА-СТА-ТШЗ**

---

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Назгүл<br>Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .................... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .................... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .................... 12
4. АУДИТЫН ТАЙЛАН .................... 15
4.1 Ерөнхий зүйл .................... 15
4.2 Материаллаг байдал .................... 16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .................... 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .................... 16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .................... 16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .................... 16
4.5.1 Завсрын аудитын талаар .................... 16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .................... 17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .................... 17
5.2 Албан шаардлага .................... 18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .................... 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БУГАТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА О.СЕРИКЖАН
ТАНАА

2023.02.24 № 179
танай ______ -ны № ______ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2022 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлог асуудал байхгүй байна.

**Аудитын гол асуудал**

Байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан, баталж ажиллаагүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Дүгнэлт-Бугат-ЭМТ хянав4-ТА

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

Дүгнэлт-Бугат-ЭМТ хянав4-ТА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **19,343,738.42** | **99,119,287.99** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 0.50 | 27,090,820.50 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 0.50 | 27,090,820.50 |
| **3121** | **Төгрөг** | 0.50 | 27,090,820.50 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.50 | 27,090,820.50 |
| **33** | **АВЛАГА** | 6,945,458.22 | 6,545,260.03 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 298,958.22 | 6,479,160.03 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 6,646,500.00 | - |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 66,100.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 12,398,279.70 | 65,483,207.46 |
| **351** | **Түүхий эд материал** | 3,371,422.00 | 56,456,349.76 |
| | Эм боох материал | 3,371,422.00 | 56,456,349.76 |
| **354** | **Хангамжийн материал** | 9,026,857.70 | 9,026,857.70 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,026,857.70 | 9,026,857.70 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **473,701,496.64** | **485,805,343.20** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 473,701,496.64 | 485,805,343.20 |
| **392** | **Биет хөрөнгө** | 467,109,496.64 | 479,213,343.20 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 435,785,201.92 | 435,785,201.92 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (46,827,244.12) | (62,498,672.68) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 83,519,172.00 | 83,519,172.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (37,462,758.76) | (46,553,675.68) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 52,302,422.59 | 98,872,904.68 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (24,332,463.64) | (30,263,614.24) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,011,955.00 | 33,011,955.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (29,077,288.35) | (32,850,427.80) |
| 39217 | Ном | 190,500.00 | 190,500.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 6,592,000.00 | 6,592,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (550,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 6,592,000.00 | 6,592,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **493,045,235.06** | **584,924,631.19** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,295,940.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 2,295,940.00 | - |
| **413** | **Өглөг** | 2,295,940.00 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 2,295,940.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 2,295,940.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **490,749,295.06** | **584,924,631.19** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 490,749,295.06 | 584,924,631.19 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 466,568,107.00 | 466,568,107.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 466,568,107.00 | 466,568,107.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,409,269.42 | 95,584,605.55 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (32,106,735.74) | 1,409,269.42 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 33,516,005.16 | 94,175,336.13 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 22,771,918.64 | 22,771,918.64 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **493,045,235.06** | **584,924,631.19** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **630,977,244.26** | **721,726,903.95** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **9,026,857.70** | **86,429,583.95** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 9,026,857.70 | 86,429,583.95 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 9,026,857.70 | 86,429,583.95 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 9,026,857.70 | 86,429,583.95 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **621,950,386.56** | **635,297,320.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 471,816,553.56 | - |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 19,766,753.56 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 452,049,800.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 91,850,113.00 | 300,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 91,850,113.00 | 300,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 22,254,500.00 | 31,856,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 22,254,500.00 | 31,856,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 36,029,220.00 | 603,141,320.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 36,029,220.00 | 603,141,320.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **597,461,239.10** | **627,551,567.82** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **597,461,239.10** | **627,551,567.82** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 562,461,239.10 | 627,551,567.82 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 373,010,605.85 | 346,258,828.53 |
| 210101 | Үндсэн цалин | 240,759,205.85 | 154,974,871.65 |
| 210102 | Нэмэгдэл | 94,106,400.00 | 152,494,407.53 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,300,000.00 | 1,499,153.00 |
| 210104 | Урамшуулал | 31,845,000.00 | 37,290,396.35 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,514,750.00 | 94,258,469.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,732,550.00 | 63,362,085.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,445,600.00 | 6,826,117.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,756,500.00 | 6,974,110.95 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 689,100.00 | 9,562,874.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,891,000.00 | 7,533,281.38 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,515,555.00 | 28,947,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,224,400.00 | 1,969,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,291,155.00 | 26,977,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29,342,599.00 | 30,246,130.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,230,500.00 | 5,471,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,977,086.00 | 21,610,100.50 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,556,113.00 | 1,961,830.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,450,200.00 | 1,202,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,128,700.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 54,348,729.50 | 72,505,758.60 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 38,515,979.50 | 57,546,615.60 |
| 210502 | Хоол, хүнс | 8,569,000.00 | 8,392,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,263,750.00 | 6,566,943.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,063,240.00 | 9,289,145.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,893,140.00 | 6,226,545.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,170,100.00 | 3,062,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,303,481.00 | 833,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,303,481.00 | 833,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,524,300.00 | 947,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 360,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 30,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 32,100.00 | 45,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 440,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 35,900.00 | 39,500.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 76,300.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 31,837,978.75 | 44,264,935.53 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,686,870.00 | 9,798,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,099,200.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 26,051,908.75 | 34,466,635.53 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 35,000,000.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 35,000,000.00 | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 35,000,000.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **33,516,005.16** | **94,175,336.13** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **33,516,005.16** | **94,175,336.13** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **595,537,133.00** | **641,877,720.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **595,537,133.00** | **641,877,720.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 452,049,800.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 452,049,800.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 91,850,113.00 | 300,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 91,850,113.00 | 300,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 22,254,500.00 | 31,856,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 22,254,500.00 | 31,856,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 29,382,720.00 | 609,721,720.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 29,382,720.00 | 609,721,720.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **585,479,282.50** | **613,786,900.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **585,479,282.50** | **613,786,900.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **550,479,282.50** | **613,786,900.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 380,096,482.00 | 395,394,200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 247,845,082.00 | 259,428,447.55 |
| 210102 | Нэмэгдэл | 94,106,400.00 | 90,068,252.45 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,300,000.00 | 6,401,200.00 |
| 210104 | Урамшуулал | 31,845,000.00 | 39,496,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,514,750.00 | 51,303,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,732,550.00 | 34,992,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,445,600.00 | 4,077,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,756,500.00 | 3,262,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 689,100.00 | 815,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,891,000.00 | 8,155,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,132,200.00 | 29,002,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,224,400.00 | 2,024,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,907,800.00 | 26,977,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29,211,299.50 | 28,138,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,547,900.00 | 4,983,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,232,999.50 | 19,810,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,980,200.00 | 1,900,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,450,200.00 | 1,444,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 61,413,920.00 | 75,104,900.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 46,358,900.00 | 60,047,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,569,000.00 | 8,150,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,486,020.00 | 6,906,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,393,000.00 | 10,371,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,955,700.00 | 7,117,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,437,300.00 | 3,254,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,425,431.00 | 833,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,425,431.00 | 833,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,567,200.00 | 957,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 360,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 30,000.00 | 30,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 45,000.00 | 45,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 450,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 35,900.00 | 39,500.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 76,300.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,725,000.00 | 22,681,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,725,000.00 | 22,681,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **35,000,000.00** | **-** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 35,000,000.00 | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 35,000,000.00 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **10,057,850.50** | **28,090,820.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **-** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **10,058,000.00** | **1,000,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,058,000.00** | **1,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 10,058,000.00 | 1,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,058,000.00 | 1,000,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(10,058,000.00)** | **(1,000,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (149.50) | 27,090,820.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 150.00 | 0.50 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.50 | 27,090,820.50 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**Төгрөгөөр**

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | | | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | 0.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 466,568,107.00 | 22,771,918.64 | 1,409,269.42 | 490,749,295.06 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **466,568,107.00** | **22,771,918.64** | **1,409,269.42** | 490,749,295.06 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **466,568,107.00** | **22,771,918.64** | **1,409,269.42** | 490,749,295.06 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **466,568,107.00** | **22,771,918.64** | **1,409,269.42** | 490,749,295.06 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 94,175,336.13 | 94,175,336.13 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **466,568,107.00** | **22,771,918.64** | **95,584,605.55** | 584,924,631.19 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 629,819,300.00 | 614,786,900.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 629,819,300.00 | 614,786,900.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 629,819,300.00 | 614,786,900.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 410,426,600.00 | 395,394,200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 271,635,600.00 | 259,428,447.55 |
| 210102 | Нэмэгдэл | 91,402,500.00 | 90,068,252.45 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,892,200.00 | 6,401,200.00 |
| 210104 | Урамшуулал | 39,496,300.00 | 39,496,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,303,300.00 | 51,303,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,992,900.00 | 34,992,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,077,600.00 | 4,077,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,262,100.00 | 3,262,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 815,500.00 | 815,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,155,200.00 | 8,155,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,002,000.00 | 29,002,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,024,400.00 | 2,024,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 26,977,600.00 | 26,977,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,138,200.00 | 28,138,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,983,600.00 | 4,983,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,810,100.00 | 19,810,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,900,000.00 | 1,900,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,444,500.00 | 1,444,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 75,104,900.00 | 75,104,900.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 60,047,900.00 | 60,047,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,150,400.00 | 8,150,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,906,600.00 | 6,906,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,371,800.00 | 11,371,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,117,700.00 | 8,117,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,254,100.00 | 3,254,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 833,700.00 | 833,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 833,700.00 | 833,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 957,500.00 | 957,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 360,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 30,000.00 | 30,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 45,000.00 | 45,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | 450,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 39,500.00 | 39,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,681,300.00 | 22,681,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,681,300.00 | 22,681,300.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 629,819,300.00 | 641,877,720.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 31,856,000.00 | 31,856,000.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 31,856,000.00 | 31,856,000.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 597,963,300.00 | 610,021,720.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 597,963,300.00 | 610,021,720.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 0.50 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.50 | 27,090,820.50 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |

| | | | |
|---|---|---|---|
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 31 | 30 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 27 | 24 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3 | 5 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **31** | **30** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 25 | 22 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 6 | 8 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Бугат сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2, 16.7-д заасан үндсэн чиг үүрэг болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажилладаг.

Тайлант онд “Сумын иргэдэд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тусламж үйлчилгээг үзүүлэх” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Иргэн бүрийн оролцоотой, эрүүл мэндийн боловсрол олгох
- Тусламж үйлчилгээг сайжруулах
- Сумын хүн амд ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх
- Хүлээгдэл, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Бугат сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайланд хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Тайлант оноос үйл ажиллагааны хувьсах зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжүүлэх тогтолцоонд шилжиж, санхүүгийн тайлангаа Эрүүл мэндийн яаманд нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Бугат сумын Эрүүл мэндийн төв 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын Эрүүл мэндийн төв 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Бугат сумын Эрүүл мэндийн төв нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 91.8 сая төгрөгөөр буюу 18.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 27,090.82 | 27,090.82 |
| Авлага | 6,945.46 | 6,545.26 | (400.20) |
| Бараа материал | 12,398.28 | 65,483.21 | 53,084.93 |

| | | | |
|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгө | 473,701.50 | 485,805.34 | 12,103.85 |
| **Нийт хөрөнгө** | **493,045.24** | **584,924.63** | **91,879.40** |
| Өр төлбөр | 2,295.94 | - | (2,295.94) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 490,749.30 | 584,924.63 | 94,175.34 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **493,045.24** | **584,924.63** | **91,879.40** |

*Эх сурвалж: Аудитын судалгаа*

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 27.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь цалингийн зардлыг 15.0 сая төгрөгөөр хэмнэсэн, эрүүл мэндийн даатгалын сангаас 12.0 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосонтой холбоотой байна.

Авлага данс оны эхэнд 6.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 0.4 сая төгрөгөөр буурч 6.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 6.6 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн 0.3 сая төгрөгийн авлагатай байснаас санхүүжилтийн авлагыг барагдуулж, тайлант онд ХХОАТ-т 1.9 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн 4.3 сая төгрөгийн авлагыг шинээр үүсгэсэн байна.

Бараа материалын данс 53.0 сая төгрөгөөр нэмэгдсэн ба энэ нь тайлант онд аймгийн ЭМГ-аас 40.8 сая төгрөгийн эмийг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн данс 12.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 1.0 сая, үнэ төлбөргүй 45.6 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгөнд тайлант онд 34.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр данс оны эхэнд 2.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсныг барагдуулж ажилласан байна.

Тайлант онд 94.2 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 91.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 529.9 сая, орон нутгийн төсвөөс 31.8 сая , нийт зарлагыг 561.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж 561.7 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 529.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 31.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 610.0 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 31.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 614.8 сая төгрөг буюу 97.6 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | | | | |
| 1 | Нэг иргэнд ноогдох нормативаар | 343,226.0 | 328,193.7 | 15032.3 | 95.6% |
| 2 | Үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ | 242,155.9 | 242,155.9 | 0.00 | 104.9% |
| 3 | Дээд шатны төсвөөс хуваарилсан | 12,581.4 | 12,581.4 | 0.00 | 100% |
| | Нийгмийн эрүүл мэнд | | | | |
| 1 | Нийтлэг үйлчилгээ | 31,856.0 | 31,856.0 | 0.00 | 100% |
| | **Дүн** | **629,819.3** | **614,786.9** | **15,032.4** | **97.6%** |

*Эх сурвалж: Аудитын судалгаа*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн яамнаас нэмэлт төсвийн дансыг хаах чиглэл ирүүлж, 2022 онд дээд шатны төсвөөс хуваарилсан мөнгө нь үндсэн дансанд тусдаа арга хэмжээ болж орж ирсэн байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Бугат сумын Эрүүл мэндийн төв 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 597.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тайлант оны батлагдсан төсвийг нийт дүнгээр 27.0 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна. Эрүүл мэндийн төв нь тайлант онд цалингийн зардлыг 15.0 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулжээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 32.2 сая төгрөгийн 10 шийдвэр гарсныг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 65.8 сая төгрөгийн орлогын 4 гүйлгээг хугацаа хоцроож оруулсан байна.

Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75%, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 70.9% байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан дүнгээр албан шаардлага өгөв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Орон нутгийн төсвөөс 2.4 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон зөрчилд 2.5 сая төгрөгийн төлбөрийн акт, жилийн эцсийн тооллого хийгээгүй, үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй, тээвэр шатахууны зардалд зарцуулсан 22.2 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэж тайлагнасан, түлш, халаалтын зардалд 17.9 сая төгрөгийг бүрдэл дутуу баримтаар шилжүүлсэн, 2.3 сая төгрөгийн эмийн өглөгийг тооцоо хийж баталгаажуулаагүй, шилэн дансны нэгдэн цахим хуудаст авлага, өглөг үүсгэсэн 9.2 сая төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй, бусад мэдээллээс 33 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данстай холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлүүдийн дүнгээр албан шаардлага өгөгдсөн байна.

Аудитаар хэрэгжилтийг давтан шалгахад 96.1 %-ийн биелэлттэй байна. Шилэн данстай холбоотой алдаа, зөрчлийг давтан гаргасан байна.

*Хүснэгт 4* Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 2,468.3 | 1 | 2,468.3 | 100% |
| Албан шаардлага | 2 | 237,126.2 | 1 | 227,884.9 | 96% |
| Зөвлөмж | 1 | 54,900.0 | 0 | 0 | 0 |
| **Нийт дүн** | **4** | **294,494.5** | **2** | **230,353.2** | **50%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 29.1 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 29.1 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Санхүүгийн байдлын тайлангийн өмнөх оны үр дүнг 50 төгрөгөөр, тайлант оны үр дүнг 8.8 сая төгрөгөөр дутуу, эм боох материалын үлдэгдлийг 8.8 сая төгрөгөөр дутуу, бараа материалын тодруулга тайлангийн эм боох материалын орлогыг 1.2 сая төгрөгөөр илүү, зарлагыг 10.0 сая төгрөгөөр илүү, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тайлант оны батлагдсан төлөвлөгөөг 0.3 сая төгрөгөөр илүү тайлагнасныг аудитын явцад холбогдох тайлангуудад залруулсан.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар 17.9 сая төгрөгийн зөрчил илэрч 17.9 сая төгрөгийн албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмж өгөв.

**5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

**5.2 Албан шаардлага**

Аудитаар дараах зөрчилд албан шаардлага өгөв.Үүнд:

1.Өмнөх оны аудитаар шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг тайлант онд давтан гаргаж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, нормын хувцас, зөөлөн эдлэл, урсгал засвар, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн төлбөрийн зардлуудаас нийтдээ 17.9 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй бүртгэж тайлагнасан тул албан шаардлага өгөв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*1.1.Илрүүлэлт*:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, удирдлага болон нягтлан бодогч нь санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар ойлголт, мэдээлэлгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг”, 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцээгүй, АОУС-250-д "Санхүүгийн тайланд хууль тогтоомж, дүрэм, журмыг анхаарах", УСНББОУС-1, АДБОУС 200 болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*1.2.Өгсөн зөвлөмж*:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн хангаж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж санхүү, бүртгэл, тайлагналын үйл ажиллагаандаа ашиглах, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаарх мэдээлэл, ойлголтоо сайжруулах;

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | Буруу тусган илэрхийлсэн | Үүнээс | | Зөвлөмж |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулсан | Залруулаагүй | |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн | 6 | 29,105.2 | | | 6 | 29,105.2 | 6 | 29105.2 | | | | |
| **Дүн** | 6 | 29,105.2 | | | 6 | 29,105.2 | 6 | 29105.2 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан. | 2 | 17,935.4 | | | 1 | 17,935.4 | 1 | | | | | |
| **Дүн** | **2** | **17,935.4** | | | **1** | **17,935.4** | **1** | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 32.2 сая, төгрөгийн шийдвэрийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 59.9 сая төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож оруулсан байна. | 1 | 32210.5 | | | 1 | 32210.5 | | |
| Дүн | 1 | 32210.5 | | | 1 | 32210.5 | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | 1 | 32210.5 | | | 1 | 32210.5 | | |